



НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 07 сарын 10 өдөр

Дугаар 8/244

Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн
244 дүгээр цэцэрлэгийн балансас
хөрөнгө шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.7, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 10,217,900.0 /Арван сая хоёр зуун арван долоон мянга есөн зуун/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Сонгинохайрхан дүүргийн 110, 176, 227 дугаар цэцэрлэгийн балансас шилжүүлж данс бүртгэлээсээ хасахыг Сонгинохайрхан дүүргийн 244 дүгээр цэцэрлэг /Ч.Нацагмаа/-т зөвшөөрсүгэй.

2. Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж авахыг Сонгинохайрхан дүүргийн 110, 176, 227 дугаар цэцэрлэгийн эрхлэгч нарт даалгасугай.

3. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Сонгинохайрхан дүүргийн 244 дүгээр цэцэрлэг /Ч.Нацагмаа/, Сонгинохайрхан дүүргийн 110 дугаар цэцэрлэг /С.Энх-Ариун/, Сонгинохайрхан дүүргийн 176 дугаар цэцэрлэг /Ц.Цэндсүрэн/, Сонгинохайрхан дүүргийн 227 дугаар цэцэрлэг /Ц.Баясгалан/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс /М.Энхболд/-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

D:\Tushaal 2019\Tushaal-1\Тушаал 2019.docx

115050000803

